



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Онцгой байдлын байгууллагаас тив, дэлхий, олон улсын болон улсын чанартай тэмцээнд оролцох алба хаагчдын бэлтгэл сургалтыг “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороонд төвлөрүүлэн хангасугай.

2. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бэлтгэл сургалтын үеийн албаны үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

3. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг тэмцээнд оролцохоор бэлтгэл хангагч алба хаагч, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч, “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороо (хурандаа Г.Эрхэмбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (хурандаа Ц.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2018 оны 03 дугаар сарын 22 ны өдрийн
А/106 дугаар тушаалын хавсралт

**ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН
БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ҮЕИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас тив, дэлхий, олон улсын болон улсын чанартай тэмцээнд оролцох алба хаагчид /цаашид "алба хаагч-тамирчин" гэх/-ыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулж, бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх, бэлтгэлийн үеийн сахилга хариуцлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг тив, дэлхий, олон улсын болон улсын чанартай тэмцээнд оролцох алба хаагч-тамирчид, "Аврагч" биеийн тамир, техник-спорт хорооны удирдлага, багш, дасгалжуулагч, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар дагаж мөрдөнө.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Онцгой байдлын байгууллагын нэрийн өмнөөс тив, дэлхий, олон улсын болон улсын чанартай тэмцээнд оролцох алба хаагч-тамирчдын бэлтгэл сургалтыг хангах зорилгоор харьяалах төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага албанаас түр чөлөөлж, "Аврагч" биеийн тамир, техник-спорт хороонд шилжүүлнэ.

2.2. Бэлтгэл сургалтад хамрагдах алба хаагч-тамирчин, тухайн алба хаагч-тамирчныг харьяалах төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, "Аврагч" биеийн тамир, техник-спорт хорооны гурвалсан гэрээ /цаашид "Гурвалсан гэрээ" гэх/ байгуулна.

Гурвалсан гэрээ байгуулснаар энэхүү журмын 2.1-т заасны дагуу алба хаагч-тамирчныг "Аврагч" биеийн тамир, техник-спорт хороонд шилжсэнд тооцно.

2.3. Алба хаагч-тамирчдын бэлтгэл сургалтад хамрагдах үеийн аюулгүй байдал, сахилга дэг журмыг энэхүү журмын 2.2-т заасан хугацаанаас "Аврагч" биеийн тамир, техник-спорт хороо хариуцан ажиллана.

2.4. "Аврагч" биеийн тамир, техник-спорт хорооноос энэхүү журмын 4.8-д заасан мэдээг үндэслэн тухайн алба хаагч-тамирчны цалинг харьяалах байгууллага тооцож олгоно.

Гурав. Баримтлах зарчим

3.1. "Аврагч" биеийн тамир, техник-спорт хороо, алба хаагч-тамирчин нь Онцгой байдлын байгууллага, төрийн алба хаагчийн нэр хүндийг өндөрт өргөж, дараах зарчмыг баримтална.

3.1.1. Онцгой байдлын байгууллагын нэр хүндийг өндөрт өргөх,

3.1.2. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйг хэлбэрэлтгүй сахих,

3.1.3. цэрэгжилч, жагсаалч байдал, цэргийн дүрмийн хэрэгжилтийг байнга хангах,

3.1.4. захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх,

3.1.5. дайчин, шуурхай, идэвх санаачилгатай, хөдөлмөрч, шударга байх.

Дөрөв. Бэлтгэл сургалтад хамруулах үеийн ажиллагаа

4.1. "Аврагч" биеийн тамир, техник-спорт хороо нь алба хаагч-тамирчны бэлтгэл сургалтыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

4.2. "Аврагч" биеийн тамир, техник-спорт хороо нь алба хаагч-тамирчны оролцох спортын төрлөөс хамааран бэлтгэл сургалт хийх газрыг тогтооно.

4.3. Тухайн спортын төрлийн дасгалжуулагч, алба хаагч-тамирчин хамтран зорилго, зорилтоо тодорхойлон хэрэгжүүлэх төлөвлөгөө, бэлтгэлийн хуваарийг гаргаж, “Аврагч” биеийн тамир, техник-спорт хорооны даргаар батлуулан мөрдөнө.

4.4. “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороо тамирчдыг хамруулах нэгдсэн арга хэмжээ болон бусад шаардлагатай арга хэмжээний хуваарийг батлан гаргаж, алба хаагч-тамирчдыг оролцуулах нөхцөл бололцоог хангана.

4.5. “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороо нь сар бүрийн 15-ны өдөр зохион байгуулах цэргийн тангараг давтах арга хэмжээнд алба хаагч-тамирчдыг бүрэн хамруулна.

4.6. Алба хаагч-тамирчны бэлтгэл сургалт, оролцох тэмцээний хуваарийг харгалзан шаардлагатай тохиолдолд жижүүр болон бусад томилгоот үүрэг гүйцэтгүүлж болно. Энэ талаар алба хаагч-тамирчинд урьдчилан мэдэгдсэн байна.

4.7. “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороо нь алба хаагч-тамирчин бүрт хувийн хэрэг хөтлөн цаг ашиглалт, үүрэг, даалгаврын биелэлт, хувийн амжилт, сахилга дэг журмын хэрэгжилтийн талаар тэмдэглэж, энэ тухайгаа алба хаагч-тамирчин бүрт энэхүү журмын 4.5-д заасан арга хэмжээний үеэр танилцуулан гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

4.8. Бэлтгэл сургалтад хамрагдаж байгаа алба хаагч-тамирчны харьяалах байгууллагад тухайн алба хаагч-тамирчныг сайшаах, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, цаг ашиглалтын талаарх мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Тав. Алба хаагч-тамирчны эрх, үүрэг

5.1. Алба хаагч-тамирчин нь энэхүү журмын гуравдугаар бүлэгт заасан зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

5.2. Алба хаагч-тамирчин нь энэхүү журмын 4.3-т заасан төлөвлөгөө, хуваарийг чанд сахин хэрэгжүүлж, энэ тухайгаа сар бүр “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороонд бичгээр сар бүрийн 20-ны өдөр тайлагнана.

5.3. Алба хаагч-тамирчин нь “Аврагч” биеийн тамир, техник-спорт хорооноос зохион байгуулах арга хэмжээ болон энэхүү журмын 4.5, 4.6-д заасан арга хэмжээнд заавал хамрагдах ба зөрчсөн тохиолдолд энэ талаар бичгээр тайлбар гаргаж, “Аврагч” биеийн тамир, техник-спорт хорооны удирдлагад танилцуулна.

5.4. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан спортын нэгдсэн цугларалт, олон улсын тэмцээнд оролцохдоо энэ талаар “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороонд албан ёсоор мэдэгдэж, оролцсон талаар тайланг тухай бүр гаргана.

5.5. Алба хаагч-тамирчин олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх, нэвтүүлэгт оролцохдоо Онцгой байдлын байгууллагын нэр хүнд, ёс зүйг эрхэмлэнэ.

5.6. Гурвалсан гэрээний биелэлтийг хугацаанд нь дүгнүүлж ажиллана.

Зургаа. Хариуцлага

6.1. “Аврагч” биеийн тамир, техник-спорт хороо Гурвалсан гэрээг алба хаагч-тамирчны бэлтгэл сургалтын дунд үед /хагас жил/, тэмцээний дараа /бүтэн жил/ дүгнэх бөгөөд нэгдсэн дүнг Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргад тайлагнана.

6.2. Алба хаагч-тамирчин биеийн тамир, спортод хориглосон эм, бэлдмэл хэрэглэсэн, худалдсан, зуучилсан, хориотой техник, мэх хэрэглэн бусдын нэр төрийг гутаан доромжилсон, спортын бусад клуб, хорооны харьяанд тэмцээнд оролцсон, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр аливаа улс төржсөн мэдэгдэл, мэдээлэл хийсэн нь гэрээг цуцлах, ажлаас халах үндэслэл болно.

6.3. Энэхүү журмын хүлээлгэсэн үүргийг зөрчсөн зөрчилд тохирсон арга хэмжээг алба хаагч-тамирчинд ногдуулна.